



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 90,157,317.33 (ерэн сая нэг зуун тавин долоон мянга гурван зуун арван долоон төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цэнгэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, устгах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001915





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт

**"Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Барилга засварын програм	9/19/2013	ш	1	750,000.00	750,000.00	750,000.00	0.00
2	Global mapper /GIS/ програм	9/19/2013	ш	1	435,867.45	435,867.45	435,867.45	0.00
3	Microsoft share point server програм	9/19/2013	ш	1	700,000.00	700,000.00	700,000.00	0.00
4	Primavera P6EPPM 6.2.1 програм	9/19/2013	ш	1	73,402,800.00	73,402,800.00	73,402,800.00	0.00
5	Төлөвлөлтийн програм	6/19/2012	ш	1	14,868,649.88	14,868,649.88	14,868,649.88	0.00
				5	90,157,317.33	90,157,317.33	90,157,317.33	
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>		ш	5 (тав)	90,157,317.33 (ерэн сая нэг зуун тавин долоон мянга гурван зуун арван долоон төгрөг гучин гурван мөнгө)	90,157,317.33 (ерэн сая нэг зуун тавин долоон мянга гурван зуун арван долоон төгрөг гучин гурван мөнгө)	90,157,317.33 (ерэн сая нэг зуун тавин долоон мянга гурван зуун арван долоон төгрөг гучин гурван мөнгө)	